

ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ СОЁЛЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ БОЛОН СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ТОЙМ

*Ч.Батцэцэг**

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого хэрэгжүүлж эхэлснээс хойш, Хятадын эдийн засаг хөгжихийн сацуу соёлын бүтээн байгуулалтанд ихээхэн амжилт олж байна. Өнөөгийн Хятад улсад тэргүүний дэвшилтэт соёлыг хөгжүүлэх, орчин үе, дэлхий дахин, ирээдүйд чиглэсэн үндэсний шинжлэх ухаан, бүх нийтийн социалист соёлыг хөгжүүлэх, ард иргэдийн оюун санааг тасралтгүй баяжуулан нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Ялангуяа боловсрол, шинжлэх ухааныг тууштай хөгжүүлж, шинийг бүтээх, олон арван сая мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд гол анхаарлаа хандуулаад байгаа юм. Шинжлэх ухаан технологийн хөгжлийн хэтийн төлвийг боловсруулж, шинжлэх ухааны дэд бүтцийг эрчимжүүлэх, нийгмийн шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухааныг зэрэгцүүлэн хөгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны чухал үүргийг тодорхойлоод байна. ХКН-ын XVI их хурлын тайлан илтгэлийн “Чинээлэг нийгмийг бүх талаар бүтээн байгуулахын тулд социалист соёлыг эрчимтэй хөгжүүлж, социалист оюуны соёл иргэншлийг бий болгох хэрэгтэй” гэсэн 7-р зүйлд Зян Зэминь цохон тэмдэглэхдээ: “Соёлын үйл хэрэг болон соёлын бүтээн байгуулалтыг идэвхтэй хөгжүүлэх хэрэгтэй гээд бүх нийтийн соёлын үйл хэргийг төрөөс дэмжин баталгаажуулж, өөрийгөө хөгжүүлэх амьжиргааны нэмэгдлийг урамшуулна. Бүх нийтийн соёлын үйл хэргийг дэмжих бодлого, арга хэмжээнүүдийг боловсронгуй болгож, үндэстний өвөрмөц онцлогтой, улсын хэмжээний соёлын томоохон төсөл, урлагийн хамтлагууд, соёлын өв хийгээд ардын язгуур урлагийн шилдэг бүтээлийг хамгаалах ажил, үндэстний цөөнх, хил хязгаарын ядуу хоцрогдсон нутаг, төвийн болон баруун бүс нутгийн соёлын хөгжлийг дэмжин тэтгэнэ”¹ гэсэн байна. Улмаар соёлын зах зээлийн тогтолцоог боловсронгуй болгон, удирдлагын механизмыг төгөлдөржүүлж, социалист соёлыг хөгжүүлэх нийгмийн таатай орчинг бий болгох хэрэгтэйг тодорхой заажээ.

Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) нь өнө эртний түүх соёлын арвин баялаг өв уламжлалтай, дуу, бүжиг, хөгжим, үндэстний өвөрмөц язгуур урлаг, ардын аман зохиол, зан заншлаараа

*Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

БНХАУ-даа онцгой байр эзэлдэг. ӨМӨЗО-ы үндэстний соёл урлаг бүх Хятадад төдийгүй дэлхий дахинд өөрийн гэсэн орон зай эзэлж, соёлын бүтээн байгуулах үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Өвөр Монголын “Хөдөө талд мөнхийн нар мандлаа”, “Овоон дээрх уулзалт”, “Үзэсгэлэнт сайхан миний нутаг” зэрэг дуу, “Савхан бүжиг”, “Сэлэмт бүжиг”, “Аяга хундган бүжиг”, “Саальчин” бүжиг, “Баарины хилэнгийн гал”, “Тал нутгийн бяцхан баатар эгч дүү нар”, “Алтан бүргэд” зэрэг жүжиг нь дотоод, гадаадад нэрд гарч, Хятадын үндэстний соёл урлагийн сонгодог бүтээл болжээ. Ялангуяа 90-ээд оноос хойш “Сэнжидмаа” бүжгэн жүжиг, “Кидан бүсгүй” манхан жүжиг, “Елан гүнж” дуурь, “Ордосын хайр” хөгжимт бүжгэн жүжиг, “Мөнгөн аяга”, “Мандухай цэцэн” монгол жүжиг, “Жанжин Цэрэн” дуурь, “Хошуун дарга та сайн байна уу?”, “Хууль цаазын товчооны дарга” драмын жүжиг, “Дөрвүүл аяга өшиглөх”, “Сур харвах” циркийн үзүүлбэр, “Би тал нутгаас ирлээ” дуу зэрэг уран бүтээл нь төрийн дээд шагнал, олон улсын тэмцээний шагналуудыг тус тус хүртжээ.² Өвөр Монголын цирк 1960 онд байгуулагдаж, одоо Хятадын циркийн урлагаар дагнан ажилладаг үндэстний цөөнхийн тоотой хэдэн циркийн нэг болсон байна. Уг циркэд монгол, дагуур, эвенк, хятад зэрэг үндэстний зуу гаруй жүжигчин ажиллаж, 90-ээд оноос хойш өдгөө хүртэлх хугацаанд Япон, Хойд Солонгос, Монгол, Австрали, АНУ, Франц, Герман зэрэг хорь гаруй улсад айлчлан тогложээ.

Монгол үндэстний урлагийн гайхамшиг болсон морин хуурыг дээдлэн хөгжүүлж, мянган хүний морин хуурын тоглолт хийсэн нь геннисийн номд орсон байна. Одоо Өвөр Монголын алдарт хуурч Чи Булга тэргүүтэй морин хуурчид 2008 онд Хятадад болох Олимпийн тэмцээний нээлтийн ёслолын ажиллагаанд 2008 морин хуурчийг хөгжимдүүлэх эрхийг аваад бэлтгэж байна. Ийнхүү Өвөр Монгол нь соёл урлагаараа Хятадын үндэстний цөөнхийн өөртөө засах таван орны дотор тэргүүлэх байр эзлэх боллоо.

Монгол Улс, ӨМӨЗО-ы хоорондын соёл урлагийн салбарын хамтын ажиллагаа тасралтгүй үргэлжилж, ялангуяа 2000 оноос хойш эрчимжиж байна. 1991 онд ӨМӨЗО-ы Хөх хот, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хоттой найрамдалт хот болсон билээ. Энэхүү найрамдалт хот болсны 10 жилийн ойн баярыг тохиолдуулан 2001 онд Улаанбаатар хотноо “Хөх хотын соёлын өдрүүд” амжилттай болж, мөн 2002 онд ӨМӨЗО-ы Хөх хотод “Улаанбаатарын өдрүүд” болж, урлаг соёлын олон арга хэмжээ зохион байгуулжээ.

2003 оны 12 дугаар сарын сүүлчээр Монгол Улсын гавъяат жүжигчин, бүжиг дэглэгч, найруулагч С.Сүхбаатар ахлагчтай Монгол Улсын Ардын Дуу Бүжгийн Чуулгын дөчөөд жүжигчин Хятадын Хөх хот, Бугат, Тайюань, Бээжин зэрэг газраар тоглолт хийсэн байна. Мөн С.Сүхбаатар нь Өвөр Монголын томоохон дуурь “Мандухай цэцэн”-ийг найруулан тавьж, зөвлөхөөр ажилласан юм.

Монгол Улсын төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч Н.Жанцанноров Өвөр Монголын нутгаар явж судалгаа хийсний үндсэн дээр “Сайхан тал” хэмээх бүтээл туурвиж, 2004 онд Улаанбаатар хотноо Монгол Улсын Морин хуурын чуулга, Өвөр Монголын дуучин Цэцэгмаатай хамтарсан тоглолт хийсэн нь олны таашаалыг хүртсэн билээ.

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын Яам, Монголын Үндэсний телевизтэй хамтран, ӨМӨЗО-ы Ардын засгийн газрын хэвлэл мэдээллийн алба, ӨМӨЗО-ы Радио телевизийн товчоо, ӨМӨЗО-ы Гадаад явдлын алба, Өвөр Монголын “Одон” телевизээс зохион байгуулсан сар шинийн баярын концерт 2004 оны 1 дүтээр сарын 14-нд Улаанбаатар хотын Соёлын төв өргөөнд болов. Монгол, Хятадын жүжигчдийн анх удаа хамтран тоглосон энэхүү концерт нь хоёр орны ард түмний нөхөрсөг харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн, монгол, хятадын жүжигчид мэргэжлийн ур чадвараа солилцсон, харилцан ойлголцсон, найрамдлаа бататгасан томоохон хэлбэрийн соёлын үйл ажиллагаа болсон юм.

ӨМӨЗО-ы радио, кино, телевиз нь олон нийтийн оюуны соёлын эрэлт хэрэгцээг хангаж байна. Өнөөгийн байдлаар тус ӨЗО-ы аймаг хотод радиогийн 13 хороо, телевизийн 13 хороо, хошуу сяний радио телевизийн 66 хороо үйл ажиллагаа явуулж байна. ӨЗО-ы радиог 91, телевизийг 62 сувгаар дамжуулдаг. Өвөр Монголын радио телевизийн монгол, хятад хэлээрх нэвтрүүлгийг Хятад даяар төдийгүй Ази, Номхон далайн 53 улс оронд цацаж байна. Ялангуяа Өвөр Монголын Радио хорооны монгол хэлээрхи нэвтрүүлгийг Монгол Улсын богино долгионы радиогоор Улаанбаатарт албан ёсоор нэвтрүүлэх болсны сацуу хоногт ойролцоогоор 20 цаг нэвтрүүлж байна.³

Монголын “Сансар” кабелийн телевизийн шугамаар ӨМӨЗО-ы Гадаадтай Соёлоор Харилцах Нийгэмлэг (ГСХН)-ийн гүйцэтгэх захирал, “Солонго” сэтгүүлийн ерөнхий редактор Мэн Шүдэ тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлах үеэр Монгол Хятадын Найрамдал Нийгэмлэгийн (МХНН) гүйцэтгэх захирал М.Чимэдцэеэ хүлээн авч уулзаад, “Солонго” сэтгүүлийн агуулга хэлбэр сайжирч, Монголын уншигчдын таашаалыг хүртэж байгаа, уг сэтгүүл нь Монгол, Хятад

хоёр орны соёлын солилцоог эрчимжүүлэх гүүр болох тухай ярьжээ. Айлчлалын үеэр төлөөлөгчид “Сансар” кабелийн телевизийн ажил байдалтай танилцаж, Монголын богино долгионы радио станц зэрэг холбогдох байгууллагад зочилж, хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцсон байна. Уг айлчлал нь хоёр улсын радио телевиз болон соёл урлагийнхны харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ихээхэн нэмэр болсон юм.

Өвөр Монголд одоогоор 76 нэр төрлийн сонин, 146 нэр төрлийн сэтгүүл гарч байна. Үүнд нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл 94, шинжлэх ухаан технологийн холбогдолтой сэтгүүл 52 хэвлэгддэг аж. Хэвлэлийн 8 газарт жилд 1500 гаруй төрлийн ном, үүнээс 220 гаруй нь монгол ном хэвлэж байна. Нийтдээ 1900 гаруй хэвлэх үйлдвэр, аж ахуйн нэгж ажиллаж байна. 90-ээд оноос хойш “Монголын Нууц Товчоо” шинээр засварласан хэвлэл, “Чингис хааны товчоон”, “Монгол ардын дуу”-ны эмхэтгэл (нийт гурван боть), “Монгол үндэстний ардын үлгэр”-ийн эмхэтгэл зэрэг 9 ном төрийн шагнал, “Монгол зан үйлийн нэвтэрхий толь” (Эдийн засгийн боть), “Монгол анагаах ухааны уламжлалт эмчилгээний арга” бүрэн эмхэтгэл зэрэг 7 ном бүх Хятадын номын шагнал, “Өвөр Монголын нэвтэрхий толь”, “Өвөр Монголын үндэстнүүдийн эв нэгдлийн түүх” зэрэг 6 ном бүх Хятадын төслийн шагналыг тус тус хүртсэн байна. Үүнээс гадна манай улсын эрдэмтэн, зохиолчдын ном бүтээлийг Өвөр Монголын хэвлэлийн газрууд олноор нь хэвлэх болжээ.

Өвөр Монгол нь Хятадын баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн бодлогын хүрээнд гадаадад соёлын харилцаагаа өргөжүүлж, үндэснийхээ соёл урлагийг түгээн дэлгэрүүлэх асуудлыг чухалчилж байна. Юуны өмнө үндэс угсаа нэгтэй, хил залгаа Монгол Улстай соёлын харилцаагаа идэвхжүүлж, манай улсын Соёл урлагийн их сургуульд Өвөр монголын жүжигчид мэргэжил дээшлүүлэх, дадлага хийх, эрдмийн зэрэг цол хамгаалах зэргээр бэлтгэгдэж байна.

Ийнхүү манай хоёр орны хувьд соёл урлагийн салбарын хамтын ажиллагаа улам өргөжин тэлж, дуучид, жүжигчид, хамтлагууд харилцан бие даасан тоглолт хийхийн сацуу Монголын урлагийн нэрт зүтгэлтнүүд, хөгжим бүжгийн багш нар, хөгжмийн зохиолчид, найруулагчид монгол үндэстнийхээ соёлын сан хөмрөгөө уудлан, өвөр монголчуудад сэтгэл харамгүй тусалж, сурталчилгааны олон хэлбэрээр хамтран ажиллах болжээ. Энэ нь нэг талаас соёлын даяаршил хүч түрэн орж ирж байгаа өнөө үед монгол үндэстний соёлын өвөрмөц уламжлал, бичиг үсэг, хэл,

түүх, зан заншлыг авч үлдэхийн тулд ялангуяа бүс нутгийн түншлэлд газар зүйн байрлал, хэл, соёл, уламжлал чухал үүрэгтэй учраас хил залгаа монгол үндэстэн, угсаатны соёлын хүрээг бэхжүүлж дархлалыг бий болгоход ач холбогдолтой юм.

Улсын хил хөдлөшгүй тогтвортой байдаг бол соёлын хил гадагшаагаа тэлж, улам хөгжиж байх жамтай. Монгол туургатны соёл иргэншлийг хамгаалах, соёлын өвөрмөц өв уламжлалыг аривжуулах, дэлхийн соёлын нийтлэг ололт амжилтаар баяжуулахад соёлын хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх явдал мэдээж чухал. Гэвч нөгөө талаас дэлхийн түүх соёлын өв санд үнэтэй хувь нэмэр оруулсан монгол үндэстний түүхийн дурсгал, уламжлал, нүүдэлчдийн соёл иргэншлийг хадгалан үлдэх, монгол үндэстний соёлын өв, үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс оюуны өмчийн хууль тогтоолыг боловсронгуй болгож, олон улсын байгууллагаас лицензи, патентын эрхийг нь авч баталгаажуулах (морин хуур, уртын дуу, хөөмий, уран нугаралт, ардын бүжиг, аман зохиол г.м), харийн соёлд уусахаас сэрэмжлэх, монгол үндэсний соёл иргэншлийн өвөрмөц дүр төрхөө хадгалан үлдэх асуудал бидний өмнө тулгарах нь зайлшгүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. ХКН-ын XVI их хурлын материал
2. “Солонго” сэтгүүл. Хөх хот. 2004.1 №115
3. Мөн тэнд.